



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН 2026 ОНЫ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2026 ОН**

“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК

2026 оны 06 дугаар сарын 16-ны өдөр

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2025-2029 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд парк нь 2026 оны хагас жилийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Байгууллагын 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд төлөвлөгөөний дагуу хугацаандаа хэрэгжиж байна. Энэ хугацаанд:

- Монгол Улсын Засгийн газрын тогтоол - 3
- Нийслэлийн Засаг даргын захирамж – 7
- Төрийн болон бусад байгууллагаас нийт 182 албан бичиг ирснээс хариутай албан бичиг нь 42 байж хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагаас бусад байгууллага, аж ахуй нэгжүүдэд нийт 122 албан бичиг явуулсан.

НЭГ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН ЗОРИЛГО: 3.3.1. БАГАНУУР, БАГАХАНГАЙ, НАЛАЙХ, ЭМЭЭЛТ ДЭХ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ДЭД БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ДУУСГАХ ТАЛААР:

1.1. Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дулааны цахилгаан станц барих зураг төслийг шинэчлэх

- Паркийн дулааны цахилгаан станц барих зураг төсвийг шинэчлэх ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийхээр эхний байдлаар “ББСМО” ХХК-тай зөвшилцөөд байна. Мөн Паркийн Цэвэрлэх байгууламж, дулааны станц барих зориулалтаар нэмэлтээр 20 га газрыг авч гэрчилгээ, гэрээ кадастрын бичгийг холбогдох журмын дагуу боловсруулж баталгаажуулж Нийслэлийн Засаг даргын захирамж гаргуулсан.

1.2. Паркийн дулааны цахилгаан станцын хууль эрх зүйн орчин судлах төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийх эдийн засгийн үр ашгийн тооцоолол хийх.

- Паркийн дулааны цахилгаан станц байгуулахтай холбоотой эрх зүйн орчны судалгааг хийж, Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох дүрэм, журам, стандартуудын шаардлагыг нэгтгэн судалгаа хийж байна.

1.3. Паркийн дэд бүтцийн (инженерийн шугам, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, ус дулаан дамжуулах 9 төв, сүлжээ)-ийн төсвийг шинэчлэх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг судлах 110/10кВ-ын 2х16 мВА чадалтай дэд станцын угсралтын ажлыг бүрэн дуусгах ажилд хяналт тавих

- Паркийн дэд бүтэц (инженерийн шугам, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, ус дулаан дамжуулах 9 төв)-ийн төсвийг шинэчлэх, ажлыг төр хувийн хэвшлийн түншлийн хүрээнд хийхээр “ББСМО” ХХК-тай зөвшилцөөд байна.

1.4. Паркийн цэвэрлэх байгууламж барих ажлыг эрчимжүүлэх.

- Цэвэрлэх байгууламжийг барих ажлын хөрөнгө оруулалтыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гадаад хөрөнгө оруулагч кампаниудтай 3-н удаагийн уулзалт хурал хийж санамж бичиг байгуулж хөрөнгө оруулалт хийх хууль эрх зүйн орчин судалж байна.

ХОЁР. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН ЗОРИЛГО: 3.3.2. БАГАНУУР, НАЛАЙХ, БАГАХАНГАЙ ДҮҮРЭГТ ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙГ ДАГАЛДАХ БУСАД ҮЙЛДВЭРИЙН ХАМТ БАЙГУУЛАХ ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИХ ТАЛААР:

2.1. Налайх үйлдвэрлэл, технологийн паркийн барилгын материалын бөөний болон ХЕТ боловсруулах ажлыг эхлүүлэх.

- Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер зарлагдаж, шалгарсан “ББСМО” ХХК-тай Нийслэлийн Засаг даргын тамгын газар НХААГ/20260103267 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна.

2.2. Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн дэд бүтцийн барилга байгууламжуудын гадна цахилгаан хангамжийн зураг төсвийг 2027 оны нийслэлийн зураг төсвийн санд хөрөнгө оруулалтыг тусгуулах ажлыг

- Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн дэд бүтцийн барилга байгууламжуудын гадна цахилгаан хангамжийн зураг төслийг 2027 оны нийслэлийн зураг төслийн санд хөрөнгө оруулалтыг тусгуулахаар саналыг хүргүүлээд байна.

2.3. Паркийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ тодотгол хийлгэх ажлыг зохион байгуулах.

- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Дээшлэх говь” ХХК-тай 01 тоот гэрээ байгуулж паркийн 120 га, 130 га дээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ тодотгол хийлгэж байна.

2.4. Паркийн 310 га газрын хянан баталгаа хийлгэн хүлээж авах.

Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Дээшлэх говь” ХХК-тай 01 тоот гэрээ байгуулж паркийн 310 га газрын хянан баталгааг хийлгэж хүлээж авсан.

2.5. Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр авах

- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2-т заасны дагуу паркийн нэгжийн техник, эдийн засгийн үнэлгээ, паркийн хөгжлийн төлөвлөгөө, паркийн нэгжийн техник, технологийн түвшний үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, гэрээ байгуулах паркийн нэгжийн жагсаалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал гэх мэт бичиг баримтыг боловсруулж албан хүсэлтийн хамт АҮЭБЯаманд хүргүүлсэн.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

3.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй хамтран ажиллаж паркийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг эрчимжүүлэх

- ТУЗ-ийн дарга болон гишүүдийн зүгээс компанийн төсөл, хөтөлбөрийн талаар хөрөнгө оруулагчдад танилцуулах уулзалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.

3.2. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, өр, авлага үүсгэхгүй байх, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн төлөвлөгөөний болон түүнтэй холбоотой гэрээ, хэлцлийн биелэлт, үр дүнг тайлагнах.

- 2025 оны жилийн эцсийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсан. Энэ онд Нийслэлийн төсвөөс 800 сая төгрөгийн төсөв батлагдсан. Төсвийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд 5 хувиар хэмнэн ажиллаж байна. Хагас жилийн байдлаар өр төлбөр үүсгэлгүй ажиллаа. Төрийн өмчийн тооллогод бүрэн хамрагдсан. Аж ахуй нэгжийн улсын тооллогод хамрагдсан.

3.3. Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн аж ахуйн нэгжийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх

- Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хагас жилийн байдлаар 250 га газар дээр шинэчилсэн гэрээ хийсэн 51 аж ахуй нэгж энэ онд шинээр гэрээ хийсэн 10 нийт 61 аж ахуй нэгж газар ашиглуулах гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс 15 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах газарт үйлдвэрийн барилга угсралтын ажлаа эхлүүлээд байгаа бөгөөд бүтээн байгуулалт 85 хувьтай явагдаж байна. Дээрх үйлдвэрүүд ашиглалтад орсноор 325 хүнийг байнгын ажлын байраар хангах ба одоогоор 7 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа эхлээд байна. 2026 оны 3 дугаар сарын 24-ний өдөр аж ахуй нэгжийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, бүтээн байгуулалтын ажлуудыг эрчимжүүлэх, бичиг баримтын бүрдлийг хангах чиглэл өгсөн.

3.4. Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх.

- Хяналт мониторингийн тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд байгууллагын дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтний орон тоог бий болгон олон улсын үнэлгээний системийг судлах ажил хийгдэж байна.

3.5. Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистик мэдээллийг боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлэх

- Албан статистик мэдээлэл боловсруулах ажлын хүрээнд паркийн нэгжүүдийн мэдээлэл, газрын кадастрын мэдээллийг нэгтгэх ажлыг эхлүүлсэн.

3.6. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд (хайрга дайрга, элс)-ын хайгуулын тусгай зөвшөөрөл авах.

- НБОГазарт хүсэлт хүргүүлсэн. Налайх дүүрэгтэй хамтад нь газар олголтыг шийдвэрлэхээр НБОГазраас АМХЭГазарлуу хүсэлт, координат цэгийг хүргүүлсэн.

3.6. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд аж ахуйн нэгжүүдэд паркийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, танилцуулга материал, товхимлуудыг түгээж, хамтарсан уулзалт зөвлөгөөн зохион байгуулах.

- Гадаад томилолт – 1
- Зочид төлөөлөгчид – 16
- Албан уулзалт – 8
- Олон улсын цахим хурал – 0,
- Сургалт, семинар -3
- Гэрээ -11
- Санамж бичиг-5 тухай бүрд нь байгууллагын үйл ажиллагааны болон, шаардлагатай хөрөнгө оруулалт, цаашид хийгдэх ажлын тухай мэдээллийг танилцуулж, хамтран ажиллах боломжуудыг эрэлхийлж ажилласан.

3.7. Хамтын ажиллагаа, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, үйлдвэрлэгчид, барилгын материалын салбарынхан, олон нийтийг хамруулсан өдөрлөг, уулзалт, хурал зөвлөгөөн зохион байгуулах.

- 2026 оны 01 сарын 05-ны өдөр БНХАУ-ын хөрөнгө оруулагчид паркийн үйл ажиллагаатай танилцсан. Парк нь хөрөнгө оруулагчдад паркийн нэгжүүд ашиглах Цахилгаан станц болон Цэвэрлэх байгууламжийн төслөө танилцуулж ТХХТ-ийн дагуу хамтран ажиллахад бэлэн гэдгээ онцолсон.



- 2026 оны 01 сарын 07-ны өдөр Налайх политехник коллежийн багш нар Налайхын Үйлдвэрлэл, Технологийн Паркийн үйл ажиллагаатай танилцсан. Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, үйлдвэрлэл–боловсролын уялдаа холбоог бэхжүүлэх зорилгын хүрээнд Налайх политехник коллежийн багш нар Налайхын Үйлдвэрлэл, Технологийн Паркт зочилж, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, үйлдвэрүүдийн бодит үйл ажиллагааг үзсэн. Уулзалтын үеэр аж ахуйн нэгжүүдэд шаардлагатай мэргэжил, ур чадвар бүхий боловсон хүчний хэрэгцээг тодорхойлох, уг хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөрийг онол, практик хосолсон хэлбэрээр хэрэгжүүлэх боломжийн талаар санал солилцсон.



- 2026 оны 01 сарын 07-ны өдөр “Дээшлэх говь” ХХК-ийн хамтран төсөл хэрэгжүүлэгч БНХАУ-ын хөрөнгө оруулалтын компани паркийн үйл ажиллагаатай танилцаж, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төслүүдийн талаар мэдээлэл авсан. Тус хөрөнгө оруулалтын компани нь БНХАУ-д дэд бүтцийн хөрөнгө оруулалт татах, санхүүгийн зөвлөгөө, эдийн засгийн менежмент чиглэлээр 12 жилийн туршлагатай мэргэжлийн байгууллага юм.



- 2026 оны 01 сарын 07-ны өдөр “Торгоны замын олон улсын тээврийн жинчин нэгтгэл” ХХК-тай Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Санамж бичгийн зорилго нь Төрийн түншлэгч, төсөл хэрэгжүүлэгч нар хамтран НҮТП-ийн дэд бүтэц, аж үйлдвэр, тээвэр логистик, худалдаа үйлчилгээний цогцолбор байгуулан ажиллах ерөнхий нөхцөлийг тодорхойлоход оршиж байна.



- 2026 оны 01 сарын 22-ны өдөр БНХАУ-ын хөрөнгө оруулалтын компани болох ММСМ-ийн төлөөлөгчид паркийн Дулааны цахилгаан станцын төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэмжээ, жилийн цахилгаан дулааны хэрэглээ, үр ашгийн тооцоолол зэрэг мэдээллийг авч ТХХТ-ийн дагуу хөрөнгө оруулалт хийн нөхцөлүүдийг сонирхсон. Паркийн зүгээс сонирхсон мэдээллийг өгч, хамтран төсөл хэрэгжүүлэх боломжтой гэдгээ илэрхийлсэн.



- 2026 оны 01 сарын 27-ны өдөр Монголын Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны удирдлагууд, төлөөлөгчид болон салбарын үйлдвэрлэгчид Үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа, дэд бүтцийн бүтээн байгуулалттай танилцаж, харилцан туршлага солилцсон. Энэхүү ажлын уулзалт нь барилгын материалын үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, дэд бүтцийн шийдлүүдийг оновчтой болгох, мөн үйлдвэрлэгчдэд тулгарч буй асуудлыг технологийн паркийн боломжуудыг ашиглан шийдвэрлэхэд чиглэгдсэн юм. Уулзалтын үр дүн: Паркийн нутаг дэвсгэрт шинээр үйлдвэр байгуулах сонирхолтой аж ахуйн нэгжүүдийг дэмжих, Түүхий эдийн чанар, стандартыг олон улсын түвшинд хүргэх лаборатори байгуулах боломжийг судлах, Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, хөрөнгө оруулалтыг татах байсан. Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын барилгын материалын хэрэгцээг дотоодоос бүрэн хангах, импортыг орлох, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой алхам болсон.



- 2026 оын 01 сарын 27-ны өдөр Цэвэрлэх байгууламжийн төсөлд хөрөнгө оруулах сонирхолтой БНХАУ-ын хөрөнгө оруулагч DZ consulting-ийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Тус уулзалтаар паркийн ХЕТ-нд тусгагдсан 1000 м3/хоног хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийн төслийн мэдээллийг бүрэн авсан. Цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг төрөл бүрээр нь өөрийн оронд хэрэгжүүлсэн арвин туршлагатай, тус дэд бүтцийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэж зах зээлд нийлүүлдэг мэргэжлийн компани юм.



- 2026 оны 01 сарын 28-ны өдөр Паркийн албан хаагчид Налайх дүүргийн соёлын ордонд дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүдийн тайлант өдөрлөгт оролцож мэдээлэл авч сонирхсон асуултанд хариулт авсан. Өдөрлөгөөр дүүрэгт болон паркийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг нийт төрийн албан хаагчдад танилцуулан мэдээлэл өгсөн.
- 2026 оны 01 сарын 30-ны өдөр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөрөнгө оруулалт худалдааны газрын Хөрөнгө оруулалтын газрын уулзалтад оролцож санхүүгийн зөвлөх үйлчилгээ авсан. Уулзалтаар паркийн 8 дэд бүтцийн ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийн хүрээнд хэрхэн оновчтой санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт татах, эргэн төлөгдөх нөхцөлүүдийг тодорхойлох талаар дэлгэрэнгүй хэлэлцсэн. Улсын болон орон нутгийн төсвийг хүлээх биш, өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хөрөнгө оруулалт татах бүхий л боломжийг эрэлхийлэн ажиллаж байна. Цаашид олон улсын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг улам өргөжүүлж байна.




- 2026 оны 02 сарын 03-нд УИХ-ын гишүүн С.Амарсайхан, УИХ-ын гишүүн бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир нар Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаатай танилцсан. Гишүүд холбогдох яам, нийслэл, дүүргийн удирдлагуудтай хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулж, паркт тулгамдаж буй асуудлуудыг ярилцсан. Паркийн үйл ажиллагааг сайжруулах дэд бүтэц оруулах хөрөнгө оруулалтын ажлыг Төр хувийн хэвшлийн хүрээнд зохион байгуулах, тулгамдаж буй асуудлуудыг ойрын хугацаанд шийдвэрлэх тодорхой шийдлүүд гаргасан. Энэхүү уулзалт нь дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүстэй төлөвлөлт дэд бүтцийн ажлуудыг уялдуулах ажлын байр нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.



- 2026 оны 02 сарын 03-ны өдөр “Эрдэнэс ҮТП” ХХК-ийн хамт олон Налайхын Үйлдвэрлэл, технологийн паркт цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор ажил хэргийн уулзалт зохион байгуулсан. “Эрдэнэс Монгол” нэгдлийн зүгээс уул уурхайн томоохон ордуудыг түшиглэн нийт зургаан байршилд Үйлдвэрлэл, технологийн парк байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Уулзалтын үеэр Налайхын Үйлдвэрлэл, технологийн паркийн төслийн явцтай танилцаж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлуулах үйл явцын талаарх практик туршлагаас суралцан, санал солилцсон. Паркуудын уялдаа холбоог хангаж, кластер хөгжлийг бий болгох зорилгоор хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийг бодитой, шуурхай мэдээллээр ханган ажиллах шаардлагатайг онцолсон.



- 2026 оны 02 сарын 06-ны өдөр АҮЭБЯ-ны дэд сайд Б.Энхтүвшинтэй Налайх Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлагууд уулзалт хийсэн. Уулзалтаар: 1. Паркийн хөгжлийн төлөвлөгөөг баталж, эцэслэх, 2. Холбогдох журмуудыг шат дараатайгаар боловсруулж, батлах, 3. Аж ахуйн нэгжүүдтэй маргаан үүсгээд буй Тэсрэх бодисын үйлдвэртэй холбоотой аюулгүйн бүсийн асуудлыг мэргэжлийн түвшинд судалж, шийдвэрлэхээр болсон. Мөн үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагааг системтэйгээр төрөлжүүлж, уялдаа холбоотой хөгжүүлэх нь зүйтэйг онцлон тэмдэглэсэн.



- 2026 оны 02 сарын 03-ны өдөр Япон улсын хөрөнгө оруулалттай Моншибасаки ХХК-ийн удирдлагуудыг хүлээн авч уулзсан. Тус компани нь Японы автомашины жижиг эд анги үйлдвэрлэн, бүтээгдэхүүнээ 100 хувь экспортод гаргаж, Японы автомашин үйлдвэрлэгч компаниудад нийлүүлдэг юм. Япон–Монголын хамтарсан хөрөнгө оруулалттай, 20 жилийн түүхтэй “Моншибасаки” ХХК нь чанарыг эрхэмлэн, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээд түвшинд байлгах зорилгоор үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Японд боловсрол эзэмшсэн монгол инженерүүд ажилладгаараа онцлогтой. Өдгөө тус үйлдвэр 40 орчим ажилтантайгаар 24 цагийн тасралтгүй горимоор ажиллаж, 74 нэр төрлийн бүтээгдэхүүнийг сард дунджаар 350 мянга, жилд 2.0 сая орчим ширхэг үйлдвэрлэн Монгол Улсын экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж байна.



- 2026 оны 02 сарын 11-ны өдөр Налайх хотын цаашдын хөгжлийн гарц, чиглэлийг тодорхойлон үүсгэн байгуулагдсан Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК, Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүс, Налайх хотын хөгжлийн корпораци ОНӨААТҮГ байгууллагууд хамтын ажиллагаагаа өнөөдөр албан ёсоор эхлүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үеэр байгууллага бүр Налайх хотын бүс нутгийн хөгжилд гүйцэтгэж буй үүрэг, хэрэгжүүлж буй ажлуудаа танилцуулж, чиг үүргийн давхцыг арилгах, нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хүрээнд уялдаа холбоотой ажиллах талаар харилцан ойлголцолд хүрсэн. Хэлэлцүүлгийн үр дүнд талууд өдөр тутам хамтран ажиллаж, мэдээлэл солилцохоос гадна байгууллага тус бүрээс төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулж, Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөлт болон Налайх хотын дэд бүтцийн суурь асуудлуудыг нэгдсэн, уялдаа бүхий төлөвлөлтийн хүрээнд шийдвэрлэхээр тохиролцсон. Энэхүү хамтын ажиллагаа нь Налайх хотын тогтвортой хөгжил, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, бүс нутгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал түлхэц болно.



- 2026 оны 02 сарын 25-ны өдөр Монгол Улсын Их Хурал-ын гишүүн Б.Мөнхсоёл Налайхын үйлдвэрлэл, технологийн парк болон түүний нэгж

Электроком Монгол ХХК-ийн үйл ажиллагаа, Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн явцтай танилцсан. УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 18 дугаар тогтоолоор байгуулагдсан “Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал дүгнэлт гаргах” үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчийн хувьд тэрээр дахин боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн нөхцөл байдал, техник технологи, тулгамдаж буй асуудал, эрх зүйн орчны хэрэгжилтийн талаар мэдээлэл авч, санал солилцсон. Уулзалтын үеэр хуулийн хэрэгжилтийг сайжруулах, зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд санал, дүгнэлт гарган, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах чиглэлээр хамтран ажиллахаа илэрхийлсэн. Уулзалт нь Налайхын үйлдвэрлэл, технологийн паркт хамтран ажиллаж буй дахин боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих, байгаль орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг илүү үр ашигтай болгоход чиглэсэн бодит алхам болсон.



- 2026 оны 03 сарын 05-ны өдөр Багахангай үйлдвэрлэл, технологийн паркт Нийслэлийн харьяа ҮТП-уудын Анхдугаар зөвлөгөөн зохион байгуулах ажлын хэсгийн уулзалт болсон. Уулзалтаар зөвлөгөөнд оролцох байгууллага, албаны хүмүүсийн судалгаа гаргах, зохион байгуулалтын ерөнхий зураглал гаргаж бэлэн байдлыг хангах, зохион байгуулалтын арга хэмжээнүүдийн талаар хэлэлцэж, төлөвлөгөө гаргасан.



- 2026 оны 03 сарын 05-ны өдөр Налайх дүүргийн Засаг дарга, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк, Парктай газар ашиглах гэрээ байгуулан ажиллаж буй үйлдвэрүүд Гурвалсан гэрээг байгуулсан. Тус гэрээ нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, тухайлбал Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмын хүрээнд

хэрэгжинэ. Гурвалсан гэрээ байгуулахын үндсэн зорилго нь: • Дүүргийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг бодлогын түвшинд уялдуулах, • Шинэ, дэвшилтэт болон өндөр технологийг дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах, • Үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг үе шаттайгаар хөгжүүлэх, • Ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, • Мэргэшсэн хүний нөөц бүрдүүлэх, шаардлагатай боловсон хүчин бэлтгэх, • Шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, сургалт судалгаа инновацийн төвийг хөгжүүлэх, • Нийгмийн хариуцлагын хүрээнд хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино.



• 2026 оны 03 сарын 06-ны өдөр Монголын жижиг дунд бизнес эрхлэгчдийн холбооны удирдлагууд ҮТП-т ажилласан. Тус холбоо нь жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, эрх ашгийг хамгаалах зорилгоор байгуулагдсан бөгөөд холбооны гишүүн хувь хүн, байгууллагын хүсэлтүүдийг НҮТП-д уламжилж, цаашид хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан ажиллахаар харилцан тохиролцсон.



• 2026 оны 03 сарын 11-ны өдөр Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, нийслэлийн эдийн засгийн шинэ төрөлжилтийг бий болгох зорилго бүхий Эмээлт эко аж үйлдвэрийн парк, Багануур үйлдвэрлэл, технологийн парк, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк-ийн удирдлагууд Хүннү хотын захирагчийн ажлын албанд уулзалтад оролцсон. Уулзалтын үеэр шинэ хотжилт, паркуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтад оновчтой хөрөнгө оруулалтыг татах, эрэмбийг тогтоох чиглэлээр санал солилцож, цаашдын үйл ажиллагаа, шинэ хотын хөгжил болон үйлдвэрлэл, технологийн паркуудын уялдаа холбоог сайжруулах талаар ярилцсан.




- 2026 оны 03 сарын 19-ны өдөр Налайх Политехник коллежоос зохион байгуулсан Орон нутагт хосмог сургалтыг хэрэгжүүлэх, Төр-хувийн хэвшлийн түншлэлийн тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх өдөрлөг, сургалт семинарт Гүйцэтгэх захирал Ч.Раднаабазар танилцуулга хийж, хэлэлцүүлэгт Панелистаар оролцсон. НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК-ийн хувьд: Өөрийн харьяа аж ахуйн нэгжүүдэд хосмог сургалтын системийг нэвтрүүлэх, үр дүнтэй хэрэгжүүлэх, цаашид тогтвортой хөгжүүлэх чиглэлд идэвхтэй хамтран ажиллах байр сууриа илэрхийлж, мэргэжлийн сургалтын байгууллагуудад сургалтын захиалга үүсгэх боломжтойг онцолсон.



- 2026 оны 03 сарын 27-ны өдөр Үйлдвэрлэл, технологийн паркуудын анхдугаар зөвлөгөөн Багахангай дүүрэгт зохион байгуулагдсан. Үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагааг уялдуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах замаар Монгол Улсад үйлдвэрлэл, технологийн паркуудыг кластер хэлбэрээр хөгжүүлэхэд уг зөвлөгөөний гол зорилго оршиж байсан. Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжөөр уг арга хэмжээг жил бүр зохион байгуулж, үйл ажиллагаа, уялдаа холбоогоо өргөжүүлэн үр дүнг хэлэлцэж хэвших, хөрөнгө оруулалтын орчин сайжирч, үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдэх, бүс нутгийн эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах бодит үр дүнд хүрнэ гэж дүгнэсэн.



- 2026 оны 03 сарын 30-ны өдөр Бриксийн олон талт улсын худалдааны олон улсын хамтын ажиллагааны хороотой хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулсан. Санамж бичгийн зорилго нь НҮТП-ийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, технологийн паркуудын уялдаа холбоог хангах, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн олон чиглэлийн хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр хамтран ажиллахад оршиж байна.



- 2026 оны 04 сарын 01-ны өдөр Монгол дахь Хятадын ерөнхий худалдааны танхимын Өвөр Монголын бизнесийн холбооны байнгын дэд тэргүүн, нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөлөгчид Паркт ажиллаж, үйл ажиллагаа болон хамтын ажиллагааны чиглэлүүдийн талаар харилцан мэдээлэл солилцсон.



- 2026 оны 04 сарын 02-ны өдөр паркийн удирдлагууд МҮХАҮТ-д зочилж, уулзалтанд оролцсон. Тус уулзалтаар Парктай хамтран ажиллаж буй аж ахуй нэгжүүдийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, цаашдын хамтын ажиллагааны боломжуудын талаар санал солилцсон. МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар нь цаашид гадаад харилцаа, хөрөнгө оруулалт, маркетинг, хууль эрхзүй, хүний нөөцийн бүх түвшинд хамтран ажиллах боломжтойг онцолсон.



- 2026 оны 04 сарын 06-ны өдөр Save the Children - Японы хүүхдийг ивээх сангаас Налайх дүүрэгт хэрэгжүүлж буй "Ойн төгөл бүтээгч хүүхдүүд" төслийн хүрээнд "Мод тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, уур амьсгалын

өөрчлөлтийг сааруулах" сэдэвт зөвлөмж сургалт явуулсан. "Ойн төгөл бүтээгч хүүхдүүд" төслийн сургагч багш Д.Доржханд, Налайх дүүргийн 5-р хорооны Нийгмийн ажилтан Б.Болортунгалаг нар НҮТП-ийн ажилтан, албан хаагчид болон Паркийн нэгж үйлдвэрүүдийн холбогдох мэргэжилтнүүдэд мод тарихын ач тус, үйлдвэрийн орчинд тарихад тохиромжтой модны талаар болон тарих, ургуулах, арчлах, хамгаалах зөвлөмж өгч, хүлэмжид ногоо тарих аргачлал болон хүлэмжийн төрлүүдийн талаар мэдээлэл өгсөн.



- 2026 оны 04 сарын 06-ны өдөр Өвөрмонголын бизнесийн холбооны Байнгын дэд тэргүүн, Нарийн бичгийн дарга Wang Shugen болон тус холбооны гишүүн байгууллагуудын төлөөлөл болох 15 аж ахуй нэгжүүдийн холбогдох албан тушаалтнууд Налайхын үйлдвэрлэл, технологийн паркт айлчлан Паркийн үйл ажиллагаатай танилцаж, хөрөнгө оруулалтын нөхцөл байдал, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч, цаашид хамтран ажиллах Санамж бичиг байгуулсан. Хятадын ерөнхий худалдааны танхимын Өвөрмонголын бизнесийн холбоо нь 2011 онд үүсгэн байгуулагдсан, бизнесийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулдаг 300 орчим гишүүнтэй байгууллага бөгөөд тус холбооноос 4 аж ахуйн нэгж Парктай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.



- 2026 оны 04 сарын 10-ны өдөр Монголын Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдаж буй Барилгын салбарын "ЧӨЛӨӨЛЬЕ" хэлэлцүүлэгт паркийн танилцуулга мэдээлэл хийгдэж тулгамдаж буй асуудлууд, тусгай зөвшөөрлийн талаар асуудал дэвшүүлсэн. Тус хэлэлцүүлэгт Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ болон холбогдох төрийн бус байгууллагууд, салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллүүд нээлттэй оролцож, санал солилцож цаашид хэрэгжүүлэх ажлын Зөвлөмж гарсан.



- 2026 оны 04 сарын 16-ны өдөр "Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих тухай журам" болон "Паркийн нэгжээс Паркийн удирдлагад төлөх хураамжийн хэмжээ, төлөх журам"-ын төслүүдийн хэлэлцүүлэг явагдсан. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль 2022 оны 07 сард батлагдсан билээ. Тус хуулиар Монгол Улсад Паркийн үйл ажиллагаа явуулах хууль, эрхзүйн орчин тогтвортой болж, төрийн зүгээс үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтүүд тодорхой болсон.



- 2026 оны 04 сарын 18-ны өдөр Япон улсын Ginza Bakery хүнсний үйлдвэрийн төлөөллүүд ҮТП-тай танилцсан. Тэд өөрсдийн бүтээгдэхүүн болон үйл ажиллагааны танилцуулга, үүсэн байгуулагдсан түүх, 38 жилийн тасралтгүй явагдаж хөгжиж ирсэн туршлагаа хуваалцаж, парктай хамтран ажиллах боломжийн талаар санал солилцсон.
- 2026 оны 04 сарын 20-ны өдөр БНХАУ-ын томоохон үйлдвэрлэгч компани болох JIANGSU NEW POWER ENERGY GROUP LLC-тэй уулзалт зохион байгуулсан. Jiangsu New Power Energy Group LLC нь эрчим хүчний үйлдвэрлэл, дулааны цахилгаан станцын үйлдвэрлэл, бүх төрлийн барилгын материалын үйлдвэр, нүүрсний худалдаа, цаасны үйлдвэр, зочид буудал зэрэг 20 гаруй салбар үйлдвэртэй бөгөөд дулааны цахилгаан станцын зураг төслийг гаргах, барьж байгуулах 14 жилийн туршлагатай. Түүнчлэн БНХАУ-д Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн барилга байгууламжийг барьсан туршлагаа Монгол Улсад нэвтрүүлэх сонирхол бий гэдгээ дурьдсан.



- 2026 оны 04 сарын 21-ны өдөр Налайхын Үйлдвэрлэл, Технологийн Паркийн үндсэн цахилгаан хангамж болох 110/10кВа-ын Тайж дэд станц ашиглалтад орсонтой холбогдуулан УБЦТС - Налайх түгээх төвийн удирдлага, холбогдох инженер техникийн албаныхан болон Паркийн нэгж үйлдвэрүүдийн төлөөллүүдийн дунд уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтаар Тайж дэд станцаас ААН-үүд хэрхэн яаж цахилгаан татах, шугам трасс хэрхэн хаагуур явах, техникийн нөхцөл авахад шаардлагатай бичиг баримтын бүрдэл, үйлдвэрүүдийн чадлын тооцоог гаргаж хуваарилах байгууламжийн ачааллыг хэтрүүлэхгүйгээр зохицуулах зэрэг асуудлуудыг хэлэлцсэн.



- 2026 оны 04 сарын 21-ны өдөр Налайхын Үйлдвэрлэл, Технологийн Парк Налайх Политехник Коллежтой Паркийн нэгж үйлдвэрүүдийн боловсон хүчнийг сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх, үйлдвэрлэлийн болон төгсөхийн өмнөх дадлагыг хамтран хэрэгжүүлэх, төгсөгчдийг ажлын байраар хангах зэрэг олон чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.



- 2026 оны 04 сарын 28-ны өдөр 2026 оныг "Бизнес эрхлэгчдийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан төр, хувийн хэвшлийн түншлэл, төрийн

байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааны чиглэл, хэрэгцээ шаардлагыг нэгтгэн тодорхойлж, бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийн боломжуудыг хэлэлцэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой Удирдах ажилтнуудын уулзалт Уламжлалт гар урлалын төвд зохион байгуулагдсан. Уулзалтаар НҮТП-ийн Гүйцэтгэх захирал Ч.Раднаабазар үйл ажиллагаагаа танилцуулж, цаашид жижиг дунд бизнесийг хэрхэн дэмжиж ажиллах, хамтын ажиллагааны түвшинг дараагийн шатанд гаргах шийдэл, халамжаас хөдөлмөрт шилжих гарц гаргалгаануудын талаар нээлттэй хэлэлцсэн.



- 2026 оны 04 сарын 29-ны өдөр БНХАУ-ын үйлдвэрлэгч Capsule House-ийн үйлдвэрийн паркт зочилж хамтын ажиллагааг эхлүүлэх, хөрөнгө оруулалтыг татах талаар санал солилцсон.



- 2026 оны 05 сарын 03-ны өдөр Монгол улсын Их хурал, Засгийн газрын гишүүн, Монгол улсын Шадар сайд Н.Номтойбаяр Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ий үйл ажиллагаатай танилцсан. Тус уулзалтад Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Н.Мандуул, НҮТП ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Раднаабазар болон Паркийн бусад албан хаагчид оролцсон. Уулзалтаар Паркийн үйл ажиллагаа, хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудыг танилцуулж, тулгамдаж буй асуудлууд болон гарц гаргалгааны саналаа танилцуулсан. Мөн Паркийн нэгж үйлдвэрүүд болох “Экоминерал трейд” ХХК, “Электрокем Монгол” ХХК нараар орж, үйлдвэрлэлийн явц, үйл ажиллагааг үзсэн.



- 2026 оны 05 сарын 09-нөөс 14-ны хооронд МҮХАҮТанхимаас зохион байгуулж байгаа БНХАУ-ын Шанхай хотын тоног төхөөрөмж үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, B2B уулзалт, хөрөнгө оруулалтын боломжуудыг гишүүддээ олгох зорилготой бизнес уулзалтад оролцсон. Аялалд хамрагдсанаар сэргээгдэх эрчим хүч, ногоон технологи, барилгын зураг төсөл, автомашины сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй газар дээр нь очиж танилцан туршлага судлан, шууд холбоо тогтоож хамтран ажиллах боломж нээгдсэн.



- 2026 оны 05 сарын 27-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эдийн засгийн өсөлтийг дэмжих, экспорт нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр томоохон мега төслүүдийг хэрэгжүүлж байгаагийн нэг нь Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүс байгуулах ажил юм. Уг ажлын хүрээнд Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах тендерт шалгарсан, гүйцэтгэгч компани болох Land Owner ХХК-тай уулзалт зохион байгуулсан.



- 2026 оны 06 сарын 04-ны өдөр Налайх дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэсээс зохион байгуулсан Nalaikh Job Fair 2026-д паркийн нэгжүүдийг хамруулан оролцсон. Парк нь нийгмийн хариуцлагын хүрээнд Налайх дүүргийн ажилгүй иргэд, паркийн нэгж үйлдвэрүүдийн хооронд холбоо тогтоож ажлын байранд зуучлах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тал дээр гүүр болж ажиллаж байна.



- 2026 оны 06 сарын 17-ны өдөр НИТХ-аар паркийн өргөтгөлийн 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж авсан.



- 2026 оны 06 сарын 18-ны өдөр Налайх дүүргийн ахмадууд Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, цаашдын төлөвлөлттэй танилцах арга хэмжээ зохион байгуулагдсан. Налайхын Үйлдвэрлэл, технологийн парк нь ахмад үеийн үнэт туршлага, дунд үеийн манлайлал, залуу үеийн бүтээлч санаачилгыг уялдуулан хөгжлийн залгамж холбоог бэхжүүлэхэд онцгой ач холбогдол өгч ажилладаг. Иймд ахмад үеийнхээ санал зөвлөгөөг сонсож, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх нь байгууллагын бодлогын нэг чухал чиглэл юм.



- 2026 оны 06 сарын 19-ны өдөр “Налайхын Үйлдвэрлэл, Технологийн Парк” ХК болон “Нэг бүс – Нэг зам” Олон улсын хөгжлийн судалгааны академи ТББ хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Үйлдвэрлэл, технологийн паркуудын уялдаа холбоог бэхжүүлэх, олон талт хөрөнгө оруулалт татах, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх чиглэлээр урт хугацаанд хамтран ОУ-ын хэмжээнд хамтран ажиллах юм. Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, судалгаа шинжилгээ, инноваци, хүний нөөцийн хөгжил, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд харилцан дэмжлэг үзүүлэн ажиллана.



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ 2026 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**
/Налайх үйлдвэрлэл, технологийн парк/

2026 оны 06 дугаар сарын 19

Улаанбаатар хот

Д/д	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт хэмжих нэгж	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт		2026 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ /сая.төгрөг/		Хэрэгжилт	Хувь
				Суурь түвшин	Зорилт от түвшин	Улс, нийслэл дүүргийн төсөв	Бусад эх үүсвэр		
НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
1.1. Улаанбаатар хот-“20минутын хот” стандарт									
1.2. Бие даасан эдийн засаг бүхий Улсын зэрэглэлтэй хот, дагуул хот									
8	1.2.1.3. Багануур Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн парк, эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг дуусгана.	“Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк байгаль орчин, нийгэмд ээлтэй эко дэвшилтэт технологи нэвтрүүлэн үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийн төслийг бодлогоор дэмжин холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавин ажиллана.	Дэд бүтцийн ажлын гүйцэтгэл, хувь	20	30	-	-	- Паркийн цэвэрлэх байгууламжийг барих ажлын хөрөнгө оруулалтыг төр хувийн хэвшлийн түнш хүрээнд гадаад хөрөнгө оруулагч кампаниудтай 3-н удаагийн уулзалт хурал хийж санамж бичиг байгуулж хөрөнгө оруулалт хийх хууль эрх зүйн орчин судалж байна. - Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер зарлагдаж, шалгарсан “ББСМО” ХХК-тай Нийслэлийн Засаг даргын тамгын газар НХААГ/20260103267 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна.	30%

							- Паркийн дотор 10,3 км урт, гадна 7,06 км нийт 17,36 км авто зам хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр 2027 оны улс, нийслэлийн төсөвт тусгуулахаар саналаа хүргүүлээд байна. Мөн Паркийн даацын замаас оффисын барилга хүртэлээх 0,4 м замын ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эхлүүлээд байна. - Паркийн хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу хагас байдлаар 250 га газар дээр шинэ гэрээ хийсэн 61 аж ахуй нэгж шинээр гэрээ хийсэн 10 нийт 61 аж ахуй нэгж газар ашиглуулах гэрээ байж ажиллаж байна. Үүнээс 15 аж ахуй үйл ажиллагаа явуулах үйлдвэрийн барилга угсралтын эхлүүлээд байгаа бөгөөд байгуулалт 85 хувьтай явагдаж Дээрх үйлдвэрүүд ашиглалтад 325 хүнийг байнгын ажлын ба хангах ба одоогоор 7 аж ахуй н ажиллагаагаа эхлээд байна. 202 дугаар сарын 24-ний өдөр а нэгжийн удирдлагуудтай уулзалт байгуулж, бүтээн байгуу ажлуудыг эрчимжүүлэх, бичиг ба бүрдлийг хангах чиглэл өгсөн.	
--	--	--	--	--	--	--	--	--

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
(2026 оны хагас жилийн байдлаар)**

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	5	13	Нийслэл, дүүрэг, холбогдох газруудаас зохион байгуулсан 12 сургалтад 44 албан хаагч, дотоод сургалт-1 удаа зохион байгуулж 7 албан хаагч нийт 13 удаагийн сургалтад давхардсан тоогоор 51 албан хаагчийг сургалтад хамруулав.
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	-	1	
			Мэргэшүүлэх сургалт	-	1	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-	
			Бусад	-	11	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	51	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	12	
			Эрэгтэй албан хаагч	-	39	
			Удирдах албан тушаалтан	-	-	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	51	
		1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	Давхардсан тоогоор 83%	
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	-	
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	-	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	-	
			Эрэгтэй албан хаагч	-	-	
			Удирдах албан тушаалтан	-	-	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	-	
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	-	
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	1	1	АЕГ-ын мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагч хамруулж сургалтын зардалд 250,000 төгрөг зарцуулсан.
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	-	
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						

4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	-	50	Цалин, шагнал, урамшуулал нь жилийн нийт төсөвт эзлэх хувь 60 хувь.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	-		Ажилчдын хоол унааны зардалд өдрийн 35000 төгрөгийг тооцож олгодог. Хагас жилийн байдлаар 81,480 сая төгрөг олгогдсон.
5.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш		2 удаагийн урьдчилсан үзлэгт хамруулсан.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш		100%
6.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	-	Ар гэрийн гачигдал гарсан 1 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгож 500,000 төгрөг, 2025 оны санхүүгийн аудитаар ЗӨРЧИЛГҮЙ дүгнэдсэн 1 албан хаагчид 2,000,000 төгрөгийн урамшуулал олгосон.

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Эрхэм зорилго, алсын хараа, тэргүүлэх чиглэл зэргийг цахим хуудсанд байршуулсан. Үйл ажиллагааны чиглэлийн дагуу хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудын явцыг цаг тухай бүрт нь мэдээллэж ажилладаг.	100%
1.2.	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Үйл ажиллагааны чиглэл, бүтэц, холбоо барих, санал хүсэлт, албан хаагчдын мэдээлэл, ажиллах цагийн хуваарийг оруулсан. Захиргааны мэргэжилтэн болон Маркетинг хариуцсан мэргэжилтний нэр, албан тушаал, утасны дугаарыг байгууллагын цахим хуудсанд шинэчлэгдсэн тухай бүрт нь байршуулдаг.	100%
1.3.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Гүйцэтгэх захирлын хариуцлагын гэрээ, биелэлт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын үйл ажиллагааны тайланг цаг тухай бүрт нь мэдээллэдэг.	100%
1.4.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгтийг Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргаж цахим хуудсанд байршуулсан.	100%
1.5.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	“Алсын хараа-2050”, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого”-ийн хүрээнд тус тус хийгдсэн тайлан, биелэлтүүдийг вэб сайтад оруулсан.	100%

1.6.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг вэб сайтад оруулсан.	100%
1.7.	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Нийт албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, холбоо барих утас, цахим хаягийг ил тод мэдээлж, өөрчлөгдсөн тухай бүрт нь шинэчлэдэг.	100%
1.8.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Улирал тус бүрээр тогтмол мэдээллэж ажилладаг.	100%
1.9.	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Барилгын салбарын статистик мэдээллийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас шууд авах боломжтой холбоосыг цахим хуудсанд оруулж өгсөн.	100%
1.10.	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах тухай бүртээ байгууллагын вэб хуудас болон орон нутгийн мэдээллийн цахим хуудсуудаар мэдээллэж ажилладаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Сул орон тоо гарсан тухай бүрт нь байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, орон нутгийн хөдөлмөр халамжийн хэлтсээр дамжуулан мэдээллэж, орон нутгийн цахим хуудсуудаар мэдээлэл түгээдэг.	100%
2.2.	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Ажилтан сонгон шалгаруулах журам, үе шатыг цахим хуудсанд нийтэлсэн бөгөөд, анкет, албан тушаалын тодорхойлолт, шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөрийн тухай мэдээллийг цахим хуудаснаас авах бүрэн боломжтой.	100%
2.3.	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	2025 оны 04 сарын 21-ны өдрийн А/19 тушаалаар Ёс зүйн зөвлөлийн гишүүд, дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд байгууллагын цахим хуудсанд өөрчлөгдсөн цаг тухайд нь оруулсан.	100%
2.4.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөрүүдийг цахим хуудсанд оруулсан.	100%
2.5.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Жил бүр шинээр томилогдсон болон ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээг оруулдаг.	100%
2.6.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Ур чадварын нэмэгдэл олгох журмыг цахим хуудсанд оруулсан.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			

3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Цаг тухай бүрт нь оруулдаг.	100%
3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Хагас бүтэн жилийн санхүүгийн тайланг цаг тухай бүрт нь мэдээллэдэг.	100%
3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Жил бүрийн аудитын дүгнэлт болон зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг цаг тухай бүрт нь цахим хуудсанд мэдээллэдэг.	100%
3.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Төлбөр хураамж, үйлчилгээний хөлс авдаггүй.	100%
3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Тухайн мэдээллүүдийг шилэн дансанд цаг тухай бүрт нь байршуулдаг бөгөөд байгууллагын вэб сайтнаас шилэн данс руу шууд холбогдох боломжийг бүрдүүлсэн.	100%
3.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;		100%
3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;		100%
3.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;		100%
3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Шилэн дансны мэдээллийг тогтмол, бүрэн гүйцэт оруулдаг.	100%
3.10.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүр цахим хуудсаар мэдээллэдэг. Байгууллагын зүгээс зарласан тендэр байхгүй.	100%

	бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан		
3.11.	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	Шилэн данс	100%
3.12.	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Байхгүй.	100%
3.13.	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Бүтээн байгуулалт болон зураг төслийн ажлын явцын талаарх мэдээллийг тухай бүрт нь байршуулдаг. Мөн улс нийслэлийн төсвөөр хэрэгжүүлж буй ажлуудыг нэгтгэн, оны эцэст мэдээлэл оруулдаг.	100%
3.14.	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Байхгүй.	100%
3.15.	Хууль тогтоомжид заасан бусад.	Улс нийслэлийн төсвөөр хийгдсэн ажлуудын явц, хэрэгжилт, мөнгөн дүнг тогтмол мэдээлж ажилладаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			
Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
4.1.	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Хамтран ажиллах хүсэлтэй аж ахуйн нэгж, хувь хүмүүст тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл зэргийг цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулдаг.	100%
4.2.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй	Тусгай зөвшөөрөл олгодоггүй.	100%

	болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.		
Хэсгийн дундаж хувь:			100%
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5.1.	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	Байхгүй.	100%
5.2.	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Байхгүй.	100%
5.3.	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Байхгүй.	100%
5.4.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Эзэмшиж байгаа 4 газрын гэрээ, гэрчилгээг цахим хуудсанд оруулсан.	100%
5.5.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;	Байгууллагын нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, санхүүгийн үйл ажиллагааны мэдээллүүдийг цаг тухай бүрт нь мэдээллэж ажилладаг.	100%
5.6.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн	НИТХ-ын 2024 оны 24/17 дугаар тогтоолоор компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг томилсон бөгөөд хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтын зарыг байгууллагын болон холбогдох цахим хуудсуудаар байршуулан нээлттэй	100%

	этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;	зарлаж сонгон шалгаруулалт явуулсан. НИТХ-ын 2025 оны 25/33 дугаар тогтоолоор ТУЗ-ийн хараат бус гишүүдийг батламжилсан. ТУЗ-ын гишүүдийн мэдээллийг вэб хуудсанд оруулсан.	
5.7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	Байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэл, тайлан дүгнэлтийг цаг тухай бүрт нь цахим хуудсанд мэдээлж ажилладаг.	100%
5.8.	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	Паркийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг цахим хуудсанд оруулсан.	100%
5.9.	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Оффисын барилга, худаг, үерийн байгууламж болон авто замын хүлээн авсан акт, дүгнэлтийг цахим хуудсанд оруулсан.	100%
5.10	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк, парктэй гэрээ байгуулсан ААН-үүд хамтарсан гурвалсан гэрээ байгуулсан. Тус гэрээний загварыг цахим хуудсанд оруулсан.	100%

	зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;		
5.11	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Байхгүй.	100%
5.12	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Байгууллагын зүгээс гарсан халамжийн зардлуудыг цаг тухай бүрт оруулдаг. 2026 оны эхний хагас жилийн байдлаар 2 халамжийн зардал гарсан байна.	100%
5.13	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	Байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл, гадаад хөрөнгө оруулагчидтай хийсэн уулзалт, уулзалтын үр дүн, нийгмийн хариуцлагын чиглэлээр хийсэн ажлууд зэрэг мэдээллүүдийг цаг тухай бүрт нь ил тод мэдээлж ажилладаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Хэрэгжилтийн дундаж хувь:			100%

ХЯНАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТӨН



Ч.РАДНААБАЗАР

Х.БЯМБАА